



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/327

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллаганы хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.56 дахь заалтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Үндэсний уламжлалт болон орон нутгийн онцлог хоол бүхий хоол, үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх, дэмжих, таниулах, сурталчилах" ажлын хүрээнд Улаанбаатар хотод зохион байгуулагдаж буй "Чингис хааны цом- 2019" олон улсын хоолны фестивальд орон нутгийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын төлөөлөгчид оролцох замын зардлын төсөв 1988.0 мянган төгрөг / нэг сая есөн зуун наян найман мянга/ -ийг хавсралтаар баталж, төсвийг орон нутгийн хөгжлийн сангийн 5.24-д заасан Чадварлаг Ховдчууд хөтөлбөрөөс, хоол үйлдвэрлэл, брэнд бүтээгдэхүүн сурталчилах төсөв 1500.0 мянган төгрөг / нэг сая таван зуун мянга/ -ийг хавсралтаар баталж, төсвийг орон нутгийн хөгжлийн сангийн 5.34-д заасан "Ховдын брэнд бүтээгдэхүүн" арга хэмжээний санхүүжилтээс тус тус санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ш.Багдал/-д даалгасугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Гантөмөр/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/327.Ch  
02 01600

Аймгийн Засаг даргын 2019 оны  
05 дугаар сарын 27-ны өдрийн  
А/327 дугаар захирамжийн хавсралт

“ЧИНГИС ХААНЫ ЦОМ-2019” ОЛОН УЛСЫН ХООЛНЫ ФЕСТИВАЛЬД  
ОРОЛЦОХОД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Оролцогчдын замын зардал	ш	14	142000	1988000
2	Аймаг бүр гэр барих	ш	1	500000	500 000
3	Аймаг бүр брэнд хоол цай хийж сурталчилах	Ш	1удаа	500000	500000
4	Аймгийн ширээ засалт	ш	1удаа	300000	300 000
5	Битүү шөлний үзүүлбэрийн сархинаг бэлтгэж хорхог хийх	ш	50	4000	200 000
	Дүн				3488000

-oOo-